



**АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН ЗАХИРГАА, ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН  
ХОРООНЫ ХООРОНД 2023-2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР БАЙГУУЛСАН  
ХАМТЫН ГЭРЭЭ**

2023 оны 03 сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

**Нийтлэг үндэслэл**

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 31 дүгээр зүйлийн 31.1, 32 дугаар зүйлийн 32.1, Эрчим хүчний салбарын 2023-2024 оны хамт /тариф/-ын хэлэлцээрийн 1.1 дэх хэсгийг үндэслэн нэг талаас Ажил олгогчийг төлөөлж “Амгалан дулааны станц” ТӨХК-ийн Захиргаа /цаашид ажил олгогч гэх/, нөгөө талаас ажилтныг төлөөлж Үйлдвэрчний эвлэлийн хороо /цаашид ажилтны төлөөлөл гэх/-ны хооронд энэхүү хамтын гэрээг байгуулж байна.

Гэрээний зорилго нь: Компанийн жигд ажиллагааг хангах, нийт ажилтнуудын хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлыг хуулиар тогтоосон баталгаанаас илүү нөхцөлөөр хангах, хөдөлмөрийн харилцааг зохицуулах, үйлдвэрлэлийн үр ашигтай, тогтвортой ажиллагаа, ажилтнуудын нийгмийн баталгааг хангахад оршино.

Энэ гэрээний заалтуудаас илүү нөхцлөөр байгуулагдсан хөдөлмөрийн гэрээний заалтууд хэвээр мөрдөгдөнө.

**Нэг. Ерөнхий зүйл**

1.1. Амгалан дулааны станц ТӨХК-ийн Захиргаа, ҮЭ-ийн хорооны хооронд 2023-2024 онд хэрэгжүүлэхээр байгуулсан Хамтын гэрээг Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газарт бүртгүүлэн мөрдөж ажиллана.

1.2. Компанийн Захиргаа нь санхүү, эдийн засгийн чадавхиас хамааран энэхүү гэрээний заалтуудыг чанд биелүүлэх, ҮЭ-ийн хороо нь хамтын гэрээний заалт, тэдгээрийн биелэлтийг хэрхэн хэрэгжиж байгаад хяналт тавьж, явц, үр дүнг хамтран хэлэлцэж байна.

1.3. Үйлдвэрчний эвлэлийн хороо нь өөрийн эрхээ Монгол Улсын хуулийн хүрээнд хэрэгжүүлэх бөгөөд Хамтын гэрээтэй холбогдох асуудлыг Захиргаатай гэрээ, хэлэлцээр, зөвлөлдөх замаар шийдвэрлэж байна.

**Хоёр. Хөдөлмөр эрхлэлтийн талаар**

2.1. Ажил олгогч нь үйлдвэрлэлийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах нөхцөл бүрдүүлнэ.

2.2.Компани, компанийн нэгж татан буугдах, ажилтнуудыг бөөнөөр халах тохиолдолд ажилтнуудын төлөөлөлд 45 хоногийн өмнө мэдэгдэж, ажилтны хууль ёсны эрх ашиг, сонирхлыг хангах талаар хэлэлцээ хийнэ.

2.3.Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын 2010 оны 16 дугаар тушаалаар батлагдсан үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолтын хүрээнд байгууллагын бүтэц, зохион байгуулалт, Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу албан тушаалын ба тарифт цалин, ажил мэргэжлийн жагсаалт, ажлын байрны тодорхойлолтыг компанийн захиргаа боловсруулж Гүйцэтгэх захирлын тушаалаар баталж мөрдөнө.

2.4.Нийт албан тушаалын 4 хувийн орон тоонд өмнө нь тус станцад ажиллаж байгаад үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогод өртөж хөдөлмөрийн чадвараа түр алдсан ажилтнуудыг авч ажиллуулна.

2.5.Үйлдвэрлэлийн удирдах албан тушаалд эрчим хүчний мэргэжлийн бус, ажлын дадлага туршлаггүй хүнийг ажиллуулахыг хориглоно.

2.6.Ажилтны буруу биш шалтгаанаар гарсан сул зогсолтын хугацаанд ажилтныг өөр ажлаар хангах боломжгүй тохиолдолд сул зогсолтонд хамруулж сул зогсолтын олговрыг уг ажилтны цаг зэргийн тарифт болон үндсэн цалингийн 60 хувиар тооцож олгох бөгөөд сул зогсолтын олговор нь салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур байж болохгүй.

### **Гурав. Цалин хөлс, нэмэгдэл хөлс, нэмэгдлийн талаар**

3.1.Компанийн Захиргаа ажилтнуудын цалин хөлсийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний өөрчлөлт, Эрчим хүчний салбарын цалингийн сүлжээний хамт /тариф/-ын хэлэлцээрийн дагуу өсгөн нэмэгдүүлнэ.

3.2.Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 550.000 /таван зуун тавин мянга/-н төгрөгөөр, Эрчим хүчний салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 880.000 /найман зуун наян мянга/-н төгрөгөөр тогтоосныг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөнө.

3.3.Дагалдан ажилтанд салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх цалин хөлс олгоно.

3.4.Хөдөлмөрийн хөлс олгохтой холбогдсон дүрэм журам, тэдгээрт оруулсан нэмэлт өөрчлөлтийг мөрдөж эхлэхээс 10 хоногийн өмнө нийт ажилтнуудад мэдээлнэ.

3.5.Ажилтан үндсэн ажлынхаа зэрэгцээ мэргэжил, ажил, албан тушаал хавсран ажиллавал үндсэн цалингийн 40 хүртэл хувиар нэмэгдэл хөлс олгоно. /ажил олгогч, ажилтан харилцан тохиролцсон байна/.

3.6.Ажилтан үндсэн ажлынхаа зэрэгцээ эзгүй байгаа удирдах ажилтныхаа ажил үүргийг түр орлон гүйцэтгэвэл компанийн захиргаа тухайн ажилтанд орлон ажиллах хугацаанд үндсэн цалингийн 40 хүртэл хувиар нэмэгдэл олгож болно. /ээлжийн амралттайгаас бусад тохиолдолд/

3.7.Ажилтан үндсэн ажлынхаа зэрэгцээ ажлын байрныхаа тодорхойлолтод заагаагүй нэмэгдэл ажил үүргийг гүйцэтгэвэл компанийн захиргаа ажилтантай тохиролцон үндсэн цалингийн 30 хүртэл хувиар нэмэгдэл хөлс олгоно.

3.8.Шөнийн цагаар ажилласан ажилтанд тухайн ажилтны дундаж цалин хөлсийг 50 хувиар тооцож үндсэн цалин дээр нь нэмэгдэл хөлс олгоно.

3.9.Эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэдэг буюу бусдаас илүү дэвшилтэт арга барилаар ажиллаж мэргэшлийн өндөр ур чадвар гаргаж байгаа ажилтанд ур чадварын нэмэгдэл олгох журмыг Гүйцэтгэх захирлын тушаалаар батлан мөрдөнө.

3.10.Сарын ажлын үр дүнгийн нэмэгдэл хөлсийг үндсэн цалин болон цаг зэргийн тарифт цалингийн 50 хүртэл хувиар дүгнэж журмын дагуу олгоно.

3.11.Жилийн ажлын үр дүнгийн нэмэгдэл хөлсийг ажилтны 5 хүртэлх сарын үндсэн цалин болон цаг зэргийн тарифт цалингийн хэмжээгээр дүгнэж журмын дагуу олгоно.

3.12.Эрчим хүчний салбарт удаан жил ажилласны нэмэгдлийг дараах байдлаар олгоно.  
Үүнд:

№	Ажилласан жил	Үүнд	
		Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөл	Хөдөлмөрийн хэвийн нөхцөл
1.	2-3 жил	15%	10%
2.	4-6 жил	25%	20%
3.	7-9 жил	30%	25%
4.	10-14 жил	35%	30%
5.	15 ба түүнээс дээш жил	40%	35%

Тайлбар: Тухайн жилд бүтэн ажилласан хугацааг 1 жилээр тооцно.

3.13.Удирдах дээд байгууллагын шийдвэрээр томилогдсон удирдах албан тушаалтан, мэргэжил, ур чадвар, дадлага туршлагыг нь харгалзан ажилд авсан ажилтны өмнө нь улсад ажилласан хугацааг эрчим хүчний салбарт удаан жил ажилласан хугацаанд тооцож эрчим хүчний салбарт удаан жил ажилласны нэмэгдлийг олгоно. Мөн хөдөлмөрийн чадвар алдсан ажилтан ажилдаа эргэн орсон тохиолдолд тус станцад өмнө нь ажиллаж байсан хугацааг эрчим хүчний салбарт удаан жил ажилласан хугацаанд тооцож эрчим хүчний салбарт удаан жил ажилласны нэмэгдлийг олгоно.

3.14.Эрчим хүчний зөвлөх инженерт үндсэн цалингийн 20%-тай, мэргэшсэн инженерт үндсэн цалингийн 15%-тай, мэргэшсэн нягтлан бодогчид үндсэн цалингийн 15 %-тай тэнцэх хэмжээний нэмэгдлийг сар бүр олгоно.

3.15.Ажлын шаардлагаар шилжин ажилласан ажилтны дагалдан, туршилтын хугацаанд үндсэн цалин ба цаг зэргийн тарифт цалин, үр дүнгийн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, хөнгөлөлт олгоно.

3.16.Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилладаг ажилтнуудад үндсэн цалингийн 10 хувиар тооцож, сар бүр ажилласан хугацаанд нь нэмэгдэл олгоно.

3.17.Ажилтны туршилтаар, дагалдангаар ажилласан, жирэмсний, амаржсаны амралт, хувийн чөлөөтэй, хүүхэд асрах чөлөөтэй хугацааг, тус компанид ажиллаж байгаад өөрийн

хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн хүн эргэж ажилдаа орсон тохиолдолд өмнө нь ажиллаж байсан хугацааг Эрчим хүчний салбарт удаан жил ажилласан хугацаанд тооцно.

3.18. Илүү цагаар болон 7 хоногийн амралтын өдөр ажилтныг ажиллуулж нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг 1.5 дахин нэмэгдүүлж олгоно. Нийтээр амрах баярын өдөр ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг 2 дахин нэмэгдүүлж олгоно.

#### **Дөрөв. Ээлжийн амралт, мөнгөн урамшуулал, шагнал, ажил, амралтын цагийн талаар**

4.1. Ээлжийн бус ажилтнуудын долоо хоногийн ажлын цаг нь 40 хүртэл байна.

4.2. Ажилтны нэг сард ажиллах илүү цагийн /даалгаврын хуудсаар/ дээд хэмжээг сарын ажлын цагийн 30 хувиас хэтрүүлэхгүй.

4.3. Станцад гарсан аваар устгах, гамшгийн үеийн ажлыг зохион байгуулах, компанийн санхүүгийн тайлан, мэдээ гаргах, төлөвлөгөө, төсөл зохиох зэрэг цаг алдалгүй яаралтай ажил гүйцэтгэх, гэрээ хэлэлцээр байгуулахаар инженер техникийн ажилтан, ажилтнууд ажлын өдрийн тогтоосон цагийг хэтрүүлэн илүү цагаар, нийтээр амрах баярын болон долоо хоногийн амралтын өдөр ажиллуулахыг Гүйцэтгэх захирал шийдвэрлэх бөгөөд уг ажилтны илүү цагаар ажилласан цагийг нөхөн амруулаагүй бол илүү цагийн хуудсаар баталгаажуулан илүү цаг ажилласны цалин хөлс олгоно.

4.4. Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилласан хугацаанд ажилтанд түүний ажилласан хугацааг харгалзан үндсэн амралт дээр нь дор дурьдсан нэмэгдэл амралтыг олгоно. Үүнд:

- 4.4.1 6-10 жил ажилласан бол ажлын 6 өдөр
- 4.4.2 11-15 жил ажилласан бол ажлын 8 өдөр
- 4.4.3 16-20 жил ажилласан бол ажлын 11 өдөр
- 4.4.4 21-25 жил ажилласан бол ажлын 14 өдөр
- 4.4.5 26-31 жил ажилласан бол ажлын 17 өдөр
- 4.4.6 32 болон түүнээс дээш жил ажилласан бол ажлын 20 өдөр нэмж олгоно.

4.5. Захиргаа нь ажилтанд өөрийнх нь хүсэлтээр үндсэн нэгжийн удирдах ажилтны тодорхойлолтыг үндэслэн ажлын 3 хүртэлх сарын олговоргүй чөлөө олгож болох бөгөөд бусад чөлөө олголтыг "Хөдөлмөрийн дотоод журам"-аар зохицуулна.

4.6. Ажилтанд ажлын цагийг дор дурьдсан тохиолдолд богиносгоно. Үүнд:

4.6.1. 6 хүртэлх сартай хүүхэдтэй эхэд 2 цаг, 1 хүртэлх настай хүүхэдтэй эхэд 1 цаг, /өрх толгойлсон ганц бие эцэгт нэгэн адил хамаарна/, жирэмсэн эхийн амралтын өмнөх нэг сард 1 цаг.

4.7. Ажлын цагийг нь богиносгосон хугацаанд дундаж цалин хөлсийг нь бүрэн олгоно.

4.8. Ажил үүргийн онцлогоос шалтгаалан завсарлах боломжгүй ажилтай ажилтныг ажил олгогч хооллох бололцоогоор хангана.

4.9.Ээлжийн ажилтай жирэмсэн эмэгтэй ажилтанд өөрийнх нь хүсэлтийг харгалзан 4 сартайгаас өдрөөр ажиллуулна. Цалин хөлс нь буурсан тохиолдолд өмнө авч байсан үндсэн цалинг олгоно.

4.10.Их болон урсгал засварын ажил, өвлийн их ачааллыг давахад хамт олноо манлайлан идэвх зүтгэлтэй ажилласан 10-аас доошгүй ажилтнуудыг дотоодын тойрон аялалын эрхийн бичгээр, Үйлдвэрчний эвлэлийн хорооны гишүүнийхээ эрх үүргийг биелүүлэн ажилласан 4 гишүүнийг гадаадын тойрон аялах эрхийн бичгээр шагнана.

4.11.Компанийн алдагдсан хөрөнгийг олж илрүүлсэн ажилтан болон гэрээт байгууллагын ажилтан иргэдэд мөнгөн урамшуулал олгож болно.

4.12.МУ-ын Хөдөлмөрийн баатар, Гавьяат ажилтан, Эрчим хүчний тэргүүний ажилтанд сар бүр 15.000 төгрөг, мөн бусад салбарын тэргүүний ажилтан цол тэмдэгээр шагнуулсан ажилтанд сар бүр 10.000 төгрөгийн нэмэгдэл урамшууллыг Гүйцэтгэх захирлын тушаалаар жилд 1 удаа олгоно. Хөдөлмөрийн баатар, Гавьяат ажилтан, салбарын Тэргүүний ажилтан цол тэмдгээр тус тус шагнуулж, давхардсан бол нэг шагналаар нь тооцож олгоно. /үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин, хурц хордлогын улмаас группт байгаа хүмүүс, ахмад настанд нэг адил хамаарах ба өөрийн хүсэлтээр болон сахилгын шийтгэлээр ажлаас халагдсан иргэдэд хамаарахгүй/.

4.13.Эрчим хүчний салбарын шилдэг байгууллага, ерөнхий инженер, менежер, шилдэг инженер, мастер, ажилтан, бүтээн байгуулсан ажлаараа шалгарсан ажилтанд Эрчим хүчний сайдын баталсан журмын дагуу шагнал, урамшууллыг олгоно.

4.14.Байгууллагын “Хүндэт дэвтэр”-т бичигдсэн ажилтныг салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин, “Хөдөлмөрийн аварга”-аар 1 ажилтныг шалгаруулж хүндэт өргөмжлөл, салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 4 дахин, “Тэргүүний ажилтан”-аар 5 ажилтныг шалгаруулж тус бүрийг өргөмжлөл, салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин, Монгол Улсын цол, одон, медалиар шагнагдсан ажилтнуудад салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр, хөдөлмөрийн баатар цолоор шагнагдсан ажилтанд салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1.5 дахин нэмэгдүүлсэн хэмжээний мөнгөн шагналаар тус тус шагнаж урамшуулна.

#### **Тав. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний хохирлыг нөхөн төлөх талаар**

5.1.Хөдөлмөрийн тухай хуулийн 125 дугаар зүйлд зааснаар зохицуулагдана.

#### **Зургаа. Ажилтнуудын нийгмийн асуудлын талаар**

6.1.Салбарын байгууллага болон тус компанид 10-аас дээш жил ажиллаж байгаа ажилтанд 50, 60 насны ойгоор нь 100.000 төгрөгтэй тэнцэх хэмжээний насны хишиг олгоно. Мөн өндөр настанд 60,70,80,90 насны ойгоор нь 100.000 төгрөгтэй тэнцэх хэмжээний насны хишиг олгоно. / Энэ заалт группт гарсан хүмүүст мөн адил хамаарна./

6.2.Ээлжийн бус ажилтанд нэг өдрийн 5000 төгрөг, ээлжийн ажилтанд гараа тутамд 7000 төгрөгийн хоолны үнийн хөнгөлөлт олгоно.

6.3.Тус компанид 3 ба түүнээс дээш сар ажилласан ажилтанд жилд нэг удаа дулааны үнийн хөнгөлөлт 100,000 /нэг зуу мянга/-н төгрөг олгоно. Энэ заалт тус компаниас тэтгэвэрт

гарсан ахмадууд, ҮО, МШӨ-ний групптэй хүмүүс, хүүхэд асрах чөлөөтэй байгаа эхчүүдэд нэгэн адил хамаарна.

6.4.Хамтын гэрээнд Эрчим хүчний салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр олгогдохоор заагдсан нэг удаагийн буцалтгүй тусламж, тэтгэмж, мөнгөн шагнал, урамшуулал, дагалдан ажилтны цалин хөлсийг 880.000 /Найман зуун наян мянга/-н төгрөгөөр, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр олгогдохоор заагдсан нэг удаагийн буцалтгүй тусламж, тэтгэмж, мөнгөн шагнал, урамшууллыг 550.000 /таван зуун тавин мянга/-н төгрөгөөр тогтоож 2023 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн олгоно.

6.5.Ажилтнуудын төрсөн эцэг эх, эхнэр, нөхөр, хүүхэд нас барж уй гашуу тохиолдоход салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх төгрөг, Үйлдвэрчний эвлэлийн хороо нь 200,000 төгрөг, ажилтан зуурдаар буюу өвчнөөр нас барсан тохиолдолд ар гэрт нь салбарын хөдөлмөрийн хөлсний хэмжээг 10 дахин хүртэл нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр, Үйлдвэрчний эвлэлийн хороо нь салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлнэ. /гэр бүлээрээ болон ах дүү, хэд хэдэн хүн ажилладаг бол зөвхөн нэг хүнд олгоно/

6.6.Тус компанийн харьяалал бүхий өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад, групп тогтоолгосон иргэд нас барвал салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх төгрөгийн тэтгэмж олгоно.

6.7.Компанийн ажилтан анх гэр бүл болоход нь салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх нэг удаагийн буцалтгүй тусламж нэг удаа олгоно. Компанийн ажилтнууд нь хоорондоо гэр бүл болбол салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлснээр олгоно. Гэр бүл болсноос хойш 5 сарын дотор хүсэлтийн дагуу олгоно.

6.8.Тус компанид ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарахаар ажлаас чөлөөлөгдсөн хүнд Эрчим хүчний салбарт ажилласан бүх жилийг тооцож ажилласан жил тутамд салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх төгрөгөөр нэг удаагийн буцалтгүй тэтгэмж олгоно. Мөн Үйлдвэрчний эвлэлийн хорооноос гарын бэлэг олгоно.

6.9.Ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор рашаан сувилалд сувилуулсны зардлыг Улсын чанартай магадлан итгэмжлэгдсэн рашаан, сувиллын илгээх бичгийг үндэслэн 10 хүртэлх хоногоор тооцож нэг өдрийн зардалд 20,000 төгрөгийг ажил олгогч, 12,000 төгрөгийг ҮЭХ-оос олгоно. Үүнд: ахмад настан, ҮО, МШӨ-ний групптэй хүмүүст нэг адил хамаарна.

6.10.Байгалийн гэнэтийн аюул /газар хөдлөлт, үер, гал, ус, онц аюултай цасан ба шороон шуурга/-д өртөж, хохирсон өрхөд хохирлын хэмжээг тооцон 500,000 хүртэлх төгрөгийн тусламж үзүүлнэ.

6.11.Үндсэн ажилтан, тэдгээрийн төрсөн эцэг, эх, эхнэр, нөхөр, хүүхэд хүнд өвчний улмаас эмчилгээний зайлшгүй шаардлагатай нөхцөл байдал үүссэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй, өрхийн нэг хүнд ноогдох орлого нь амьжиргааны баталгаажих доод түвшинд хүрэхгүй тохиолдолд өөрийн хүсэлтийг харгалзан тухайн ажилтанд жилд нэг удаа салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх мөнгөн тусламж үзүүлнэ. / гэр бүлээрээ болон ах дүү, хэд хэдэн хүн ажилладаг бол зөвхөн нэг хүнд олгоно/

6.12. Нийт ажилтнуудын 0-16 насны хүүхдүүдэд хүүхдийн баяраар гарын бэлэг өгнө. Мөн тус компанийн ажилтны хүүхэд ЕБС-ийн 12 дугаар ангийг А үнэлгээтэй төгссөн бол гэрчилгээг нь үндэслэн нэг удаа 50,000 төгрөгийн урамшуулал олгоно.

6.13. Амаржсан эхчүүдэд хүүхдээ 2 нас хүртэл асрах хугацаанд сар бүр 80,000 /наян мянга/-н төгрөгийн тэтгэмж олгоно. Ажилдаа эргэн орсон тохиолдолд тэтгэмжийг олгохгүй.

6.14. Ажил олгогч эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүрийн 5-ны өдрийн дотор шилжүүлэх асуудлыг хариуцна. Үүнд ажилтны төлөөлөл хяналт тавина. Шимтгэлийг шилжүүлээгүй үед нь ажилтны эмнэлэгт хэвтэж өөрөө төлбөрөө төлсөн баримтыг үндэслэн хохирлыг ажил олгогч төлнө.

6.15. Ажилтнуудад ажиллах хугацаанд нь өдрийн 2000 төгрөгөөр тооцож унааны хөнгөлөлт олгоно.

6.16. Цагаан сар, Хүүхдийн баяр, Эрчим хүчний ажилтны өдөр, Шинэ жилийн баярын өдрүүдэд ажилтнуудад хүндэтгэл үзүүлнэ.

6.17. Компанийн бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтөөр ажлын байр хасагдсан, орон тоо цөөрсөн үндэслэлээр хөдөлмөр эрхлэлтийн харилцаа цуцлагдаж байгаа ажилтнуудын нийгмийн баталгааг хангах зорилгоор:

6.17.1. Эрчим хүчний салбарт 1-4 жил ажилласан бол 4 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний,

6.17.2. Эрчим хүчний салбарт 5-10 жил ажилласан бол 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний,

6.17.3. Эрчим хүчний салбарт 11-15 жил ажилласан бол 12 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний,

6.17.4. Эрчим хүчний салбарт 16-аас дээш жил ажилласан бол 24 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг тус тус олгоно.

### **Долоо. Ажилтнуудын мэдлэг, мэргэжил, боловсролыг дээшлүүлэх талаар**

7.1. Ажилтнуудын ажлын байрны сургалтыг төлөвлөгөөний үндсэн дээр зохион байгуулж гарын авлага, шаардлагатай техник хэрэгслээр хангана.

7.2. Боловсон хүчний бодлогын хүрээнд компанийн зардлаар гадаад, дотоодын их, дээд сургууль, коллежид шаардлагатай мэргэжлээр мэргэжилтэн давтан бэлтгэх зорилгоор ажилтныг гэрээгээр суралцуулж болно.

7.3. Эрчим хүчний салбарын хэмжээнд ажил мэргэжлийн уралдаан, тэмцээнд зохион байгуулалттай оролцож шинэ арга барил, ажлын туршлага мэдээлэл солилцоно.

7.4. Ажилтны дагалдан сургалтын хугацаа нь 3 хүртэл сар байна.

7.5. Компанийн захиалгат мэргэжлээр инженер техникийн болон бусад ажилтан ажил олгогчтой тохиролцсоны үндсэн дээр мэргэжил дээшлүүлэх их дээд сургууль, коллежид сурахаар бол төлбөрийг гэрээний дагуу компани олгоно.

## **Найм. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах талаар**

8.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг сурталчлах, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна.

8.2. Компанийн ажилтнуудын ажлын байрны онцлогт тохирсон ажлын хувцасны хангалтыг нэгдсэн журмаар зохион байгуулах арга хэмжээ авна.

8.3. Ажлын байрны хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, үйлдвэрлэлийн эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах, мэргэжлээс шалтгаалах өвчин, хурц хордлогоос урьдчилан сэргийлэх, тоосжилт, чийгшлийг бууруулах ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэнэ.

8.4. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчныг сайжруулах төлөвлөгөөтэй ажиллахын зэрэгцээ олон нийтийн бусад байгууллагатай хамтарч ажиллана.

8.5. Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг нийлүүлэхээс өмнө чанарын байдалд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн ажилтан хамтран үзлэг шалгалт хийх ба олгох хугацаа ашиглалтад нь хяналт тавьж ажиллана. Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл хугацаандаа олгогдоогүй бол хожимдуулсан хугацааг элэгдлийн хугацаанд тооцохгүй.

8.6. Хяналтын хэлтэс нь нийт ажлын байранд хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.

8.7. Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлтэй ажлын байранд ажилладаг ажилтнуудад хор саармагжуулах бүтээгдэхүүн олгоно.

8.8. Ажилтнуудыг жил бүр эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт хамруулна. Эмчийн дүгнэлтийг үндэслэн эрүүлжүүлэх ажлыг Үйлдвэрчний эвлэлийн хороотой хамтран зохион байгуулна. Зардлыг ажил олгогч 100 хувь хариуцна.

8.9. Ажилтнуудын ажлын хувцсыг сард 4 удаа угааж цэвэрлэнэ.

8.10. Хөдөлмөрийн чадвар түр алдалтыг бууруулах зорилгоор ажил олгогч нийт ажилтнуудад 3 сарын турш цайны газраар аарц, чацаргана олгох бөгөөд Үйлдвэрчний эвлэлийн хороо нь жилд 2 удаа гишүүддээ дархлаа дэмжих бүтээгдэхүүн олгоно.

### **Ес. Үйлдвэрчний эвлэлийн эрхийг хангах талаар**

9.1. Ажилтны төлөөлөл нь ажилтнуудын ажлын байрны нөхцлийг сайжруулах, хөдөлмөр эрхлэлтийг тогтвортой байлгах, цалин хөлсийг үе шаттай нэмэгдүүлэх, ХАБЭА, нийгмийн асуудлыг сайжруулахад гол анхаарлаа чиглүүлнэ.

9.2. Үйлдвэрчний эвлэлийн эрхийн тухай хуульд заасан эрх, баталгааг хангахын зэрэгцээ компани нь:

9.2.1. Үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн татварыг бэлэн бусаар хурааж Үйлдвэрчний эвлэлийн хорооны дансанд шилжүүлнэ.

9.2.2. Үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагаа нь ажлын бус цагаар явагдах боловч шаардлагатай үед дараах ажиллагааг ажлын цагт явуулж болно.

9.2.3. Хамтын гэрээ боловсруулах, хэлэлцэх, үр дүнг хэлэлцэх бололцоогоор хангана.

9.2.4. Хамтын гэрээнд тусгагдсан сургалт, зөвлөгөөн хийх байраар хангана.

9.3. Ажил олгогч Үйлдвэрчний эвлэлийн орон тооны сонгуульт ажилтанд Хамтын гэрээнд тусгагдсан дараах хөнгөлөлт, урамшуулалыг олгоно. Үүнд:

9.3.1. Сар, жилийн үр дүнгийн урамшуулал

9.3.2. Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл

9.3.3. Удаан жилийн нэмэгдлийг Эрчим хүчний салбарт 2-оос доошгүй жил ажилласан бол ажилласан жилээр тооцон олгоно.

### Арав. Гэрээг биелүүлэх талаар

10.1. Гэрээгээр хүлээсэн үүрэг зөрчигдсөн тохиолдолд аль нэг тал нь маргаантай асуудлаар төлөөлөгчдийн хуралдааныг 7 хоногийн дотор зарлан хуралдуулах эрхтэй бөгөөд нөгөө талдаа албан бичгээр мэдэгдэнэ.

10.2. Гэрээний талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно.

10.3. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх явцад талуудын үйл ажиллагаанд саад учруулсан этгээдэд хариуцлага хүлээлгэх асуудлыг Монгол улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

10.4. Хамтын гэрээ нь талууд гарын үсэг зурж, эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн өдрөөс эхлэн дараагийн гэрээ байгуулах хүртэлх хугацаанд хүчинтэй.

10.5. Удирдлагын бүтэц бүрэлдэхүүн, өмчлөлийн харьяалалд өөрчлөлт орох нь энэхүү хамтын гэрээг цуцлах үндэслэл болохгүй.

10.6. Гэрээний биелэлтийг жилд 2 удаа талууд хамтран дүгнэнэ.

### Арван нэг. Хөдөлмөрийн маргааны талаар

11.1. Хөдөлмөрийн маргааныг хөдөлмөрийн маргаан таслах комисс нь эрх бүхий байгууллагын баталсан дүрмийг удирдлага болгон Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

#### АЖИЛ ОЛГОГЧИЙН ТӨЛӨӨЛӨЛ:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

СЭЗХ-ИЙН ДАРГА БӨГӨӨД

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН

БҮРТГЭСЭН: БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ХӨДӨЛМӨР ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС  
ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦАА, БҮТЭЭМЖ ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН  
МЭРГЭЖИЛТЭН

М.МӨНХӨӨ

Ө.УДВАЛ

Г.САРУУЛ

#### АЖИЛТНЫ ТӨЛӨӨЛӨЛ:

ҮЭ-ИЙН ХОРООНЫ ДАРГА

ҮЭ-ИЙН ХОРООНЫ ТЭРГҮҮЛЭГЧ:

ҮЭ-ИЙН ХОРООНЫ ТЭРГҮҮЛЭГЧ

Б.НАРАНЧИМЭГ

Б.МӨНГӨНШАГАЙ

А.БЯМБАДОРЖ